

ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2013 оны 1-р сарын 23-ны байдлаар*


2013 оны 1-р сарын 23-ны байдлаар гол нэрийн барааны үнийг дүнгээр нь өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 7.0 хувь, өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад 1.6 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2013 оны 1-р сарын 23-ны байдлаар өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад үхрийн махны үнэ 7.5-9.0 хувь, хонины ястай махны үнэ 15.7 хувь, адууны махны үнэ 8.1 хувь, ямааны махны үнэ 13.7 хувиар өссөн байна.

Махны үнийг өмнөх 7 хоногийн үнэтэй харьцуулахад үхрийн махны үнэ 2.1-2.5 хувь, хонины ястай махны үнэ 4.5 хувь, ямааны махны үнэ 0.9 хувь, адууны махны үнэ 3.8 хувиар өссөн байна.

2013 оны 1-р сарын 23-ны байдлаар 1 кг хонины /ястай/ махны үнэ дунджаар 7225 төгрөг, хонины цул мах 7120 төгрөг, үхрийн /ястай/ мах 7814 төгрөг, үхрийн цул мах 8857 төгрөг, ямааны мах 5350 төгрөг, адууны мах 5967 төгрөгийн үнэтэй байлаа (Зураг 1; 2).

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ **Зураг 2.** Цул махны жижиглэн худалдааны дундаж үнэ




Гурилын үнэ: 2013 оны 1-р сарын 23-ны байдлаар гурилын үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад савласан дээд гурилын үнэ 0.9 хувь, задгай 1-р зэргийн гурилын үнэ 2.6 хувиар өссөн байв. Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад гурилын үнэ тогтвортой байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2013 оны 1-р сарын 23-ны байдлаар элсэн чихрийн үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 0.2 хувиар буурсан бол, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.

Цагаан будааны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 0.6 хувиар буурсан бол, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна (Зураг 3).

Зураг 3



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2013 оны 1-р сарын 23-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 5.3 хувь, луувангийн үнэ 4.1 хувь, байцааны үнэ 19.7 хувь, сонгины үнэ 17.7 хувиар өсчээ.

Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад байцааны үнэ 4.5 хувь, төмсний үнэ 1.9 хувиар өссөн бол, луувангийн үнэ 2.5 хувиар буурч, сонгины үнэ тогтвортой байна.

Сүү, өндөг, ургамлын тос, цөцгийн тосны дундаж үнэ: 2013 оны 1-р сарын 23-ны байдлаар өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 500 граммын савласан сүүний үнэ 6.5 хувь, 1 литрийн савласан сүүний үнэ 8.2 хувь, задгай сүүний үнэ 1.7 хувиар өсчээ.

Өмнөх 7 хоногийн дундаж үнэтэй харьцуулахад 500 граммын савласан сүүний үнэ 0.8 хувь, 1 литрийн савласан сүүний үнэ 1.0 хувиар өссөн байна.

Ургамлын тосны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй болон, өмнөх 7 хоногийн үнэтэй харьцуулахад тогтвортой байна. Харин цөцгийн тосны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 0.9 хувиар өссөн бол, өмнөх 7 хоногийн үнэтэй харьцуулахад тогтвортой байна.

Хүнсний гол нэрийн барааны үнэ, аймгаар

Хүнсний гол нэрийн барааны 7 хоногийн үнийн судалгаанд аймгийн төвүүдээс гурил, хонь, ямаа, үхрийн мах, цагаан будаа, шингэн сүү, элсэн чихрийн үнийг судалдаг (Хавсралт хүснэгт 3).

Гурилын үнэ: 2013 оны 1-р сарын 23-ны байдлаар аймгийн төвүүдийн хүнсний зах, дэлгүүрт хэрэглээ ихтэй 1-р зэргийн гурилын үнэ 630-1000 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна. Гурилын үнийг өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад Хөвсгөл, Өмнөговь аймагт 25-50 төгрөгөөр өсч, Баян-Өлгий аймагт 20 төгрөгөөр буурсан байна.

Дорнод аймагт 1-р зэргийн гурилын үнэ хямд буюу 630 төгрөг байхад, Хөвсгөл аймагт 1000 төгрөг байгаа нь өндөр үнэ байна.

Махны үнэ: 2013 оны 1-р сарын 23-ны байдлаар хонины махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Баян-Өлгий, Ховд, Архангай, Булган, Өвөрхангай, Дорнод, Хэнтий аймагт 100-500 төгрөгөөр өсч, Баянхонгор, Дархан-Уул аймагт 100-500 төгрөгөөр буурчээ. Хонины махны үнэ Дархан-Уул аймагт 7100 төгрөг байгаа нь өндөр бөгөөд Говьсүмбэр аймагт 5000 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байв.

Үхрийн махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Ховд, Архангай, Хөвсгөл, Дорнод аймагт 100-500 төгрөгөөр өсч, Дархан-Уул аймагт 100 төгрөгөөр буурчээ. Үхрийн махны үнэ Дорноговь аймагт 8000 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ бөгөөд Баян-Өлгий аймагт 5500 төгрөгөөр зарагдсан нь хямд үнэ байв.

Ямааны махны үнэ Увс, Ховд, Өвөрхангай, Дархан-Уул, Дорнод, Хэнтий аймагт 100-1000 төгрөгөөр өссөн бол, Баянхонгор, Хөвсгөл аймагт 300-500 төгрөгөөр буурсан байна. Ямааны мах Говьсүмбэр аймагт хямд 4000 төгрөг байхад, Өмнөговь, Ховд аймагт 6000 төгрөгөөр зарагдаж буй нь хамгийн өндөр үнэ байна.

Малын сүүний үнэ: 2013 оны 1-р сарын 23-ны байдлаар малын сүү аймгуудад 1000-2500 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байна. Сүүний үнэ Завхан, Өвөрхангай, Хөвсгөл, Дархан-Уул, Дорнод аймагт 100-500 төгрөгөөр өсч, Дундговь аймагт 100 төгрөгөөр буурсан байна. Өвөрхангай, Өмнөговь аймагт хамгийн /2500 төг/ өндөр үнэтэй байна.

Цагаан будаа, элсэн чихрийн үнэ: 2013 оны 1-р сарын 23-ны байдлаар цагаан будааны үнийг өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад Хөвсгөл аймагт 50 төгрөгөөр өссөн байна. Аймгуудад цагаан будаа 1 кг нь 1500-1800 төгрөгөөр худалдаалагдаж байна.

Элсэн чихрийн үнийг өмнөх 7 хоногийн үнэтэй харьцуулахад Дундговь аймагт 100 төгрөгөөр өссөн байна. Аймгуудад элсэн чихэр 1 кг нь 1500-1800 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.